

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ
ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛЬ
“МОНГОЛ СУДЛАЛ”

Эрдэм шинжилгээний сэтгүүл

Боть XLVIII (610)

DOI: 10.22353/ms20244816

**АЯГАТАЙ БҮЖГИЙН ХУВЬСАЛ: ШАШНЫ ЗАН ҮЙЛИЙН
БЭЛГЭДЛЭЭС НҮҮДЭЛЧДИЙН СОЁЛЫН ИЛЭРХИЙЛЭЛ**

Намираа

Хураангуй: Судалгаа нь аягатай бүжгийг, хундагатай бүжиг, савхтай бүжгийг багтаасан бүжгийн төрөл зүйлийн соёлын бэлгэдэл, түүхэн хувьслыг өгүүлэхийн улмаар аягатай бүжиг нь эртний шашны тахилгаас үүсэлтэй бөгөөд аяга, хундага барих бүжгийн хөдөлгөөн нь шашны тахилгад гүн гүнзгий бэлгэдлийн утгатай байгааг тодруулна. Аягатай бүжиг нь шашны зан үйлийн хэрэглүүрээс нүүдэл соёлын бэлгэдлийг агуулж, орчин үеийн нийгэмд соёлын өв залгамжлах чухал ач холбогдолтой байгааг илрүүлсэн. Судалгаагаар аягатай бүжиг нь өөр өөр соёлд олон тооны бэлгэдлийн үүрэг гүйцэтгэснийг харуулсан бөгөөд аягатай бүжиг болон эртний шашны тахилгын хоорондын уялдаа холбоо, нүүдэлчдийн амьдралын хэв маягийн бэлгэдэл болох үүрэг, нүүдэлчдийн соёлыг орчин үед илэрхийлсэн байдал, нүүдэл ба суурьшил хоорондох аяганы өөр өөр соёлын тайлбар, бэлгэдлийн утгыг гэрч нотолгоотой тайлбарласан.

Түлхүүр үг: Аягатай бүжиг, соёлын бэлгэдэл, шашны ёслол

Бүжиг нь хүн төрөлхтний соёлыг хөдөлгөөнөөр хүүрнэх арга барилын нэг төрөл болохын хувьд тухайн үндэстний итгэл үнэмшил, дадал зуршил, онцлогийг нүдний өмнө дэлгэн харуулдаг. Үндэстэн бүрийн соёл нь өөрийн утга зохиол, урлагт тусгах, ялангуяа үндэсний оюун санаа, сэтгэл хөдлөлийн үр дагаврыг илэрхийлэх, оюун санааны бэлгэдэл болсон тод, тодруун дүрслэлээр дамжуулж болно. Тэр дундаа нүүдэлчдийн ан агнуур, мал аж ахуй, шашны тахилга, үндэсний баатруудын дүрийг тусгасан баялаг, олон талт уран зохиолын хэлбэрүүдтэй байхаас үл хамааран үндэсний соёл, бүс нутгийн өнгө төрхийг агуулсан байдаг. Бүжгийн олон төрлүүдийн дотроос аягатай бүжиг нь хөгжим, хувцас, гэрэл, бүжгийн онцлогийг хослуулан өвөрмөц илэрхийлэлтэй нь тэр үндэстний өдөр тутмын амьдралыг тусгах төдийгүй соёлын гүн утгыг шингээсэн байдаг. Тухайлбал, Монгол аягатай бүжиг (хундагатай бүжиг, дарсны хундагатай бүжиг ч гэж нэрлэдэг) ӨМӨЗО-ны Ордос нутгаар голчлон дэлгэрсэн бөгөөд найр наадамд оролцдог бүжгийн төрлүүдийн нэг нь юм. Аягатай бүжиг нь зөвхөн соёлын үзүүлбэр төдийгүй шашны болон нийгэм түүхийн бэлгэдэлтэй. Энэхүү бүжиг нь шашны тахилгын үйл хөдөлгөөний эх үүсвэртэй байж, хожим нь тоглолтын онцлогтой ордны бүжиг болон хөгжиж, улмаар ард түмний дунд өргөн тархсан байна. Одоо болохоор аягатай бүжгийг уламжлалт болон үндэстний төлөөллийн бүжиг болгожээ.

Аягатай бүжгийн гарал үүсэл, хувьсал нь шашны болоод нийгмийн янз бүрийн зан үйлд ихээхэн тусгагдсан байдаг. Эдгээр бүжиг нь зугаа цэнгэлийн нэг хэлбэр болохоос гадна соёлын дамжуулалт, шашны зан үйлийн чухал хэсэг нь болсон байна. Энэ тухайд түүхэн сурвалжид тэмдэглэж үлдсэн зүйл бий.

Түүхэн баримтаас үзвэл, “Дуу Ла” (倒喇) нь Жинь болон Юань гүрний үед маш алдартай акробатын дуу, бүжиг бөгөөд дуулж бүжиглэхийг хослуулан, олон төрлийн жүжиг тоглож дуулдаг урлагийн төрөл байсан. Энэхүү урлагийн төрөл нь Мин, Чин гүрний үед алдагдсан боловч түүний соёлын өв, уран сайхны онцлог нь нүүдэлчдийн бүжгийн урлагт хадгалагдан үлдсэн ба өнөө үед өргөн дэлгэрч буй аягатай бүжиг, тайзны Дэн (зулын бүжиг гэж бас нэрлэдэг) бүжиг нь энэхүү соёл урлагийн уламжлалын үргэлжлэл юм. Тухайлбал, толгой дээрээ янз бүрийн сав суулга барин бүжиглэх үзэгдэл энэ соёлыг уламжлуулж хуримтлуулсан, тус урлагийг өргөжүүлсний нэгэн жишээ юм¹. “Өнгөрсөн гүрний хуучны сонсол: Яндугийн (燕都) холимог дуулианууд” хэмээх эртний баримт бичгээс харахад “Дуу Ла” (倒喇) жүжгийн толгой дээрээ дэнлүүтэй бүжиглэх дүрслэл нь Юань гүрний үед энэ урлагийн төрөл дэлгэрч байсныг илтгэж байна. Энэ төрлийн тоглолт нь ур чадварын илэрхийлэл болохоор үл барам тухайн үеийн нийгэм соёл, урлагийн чиг хандлагыг харуулсан соёлын өвийн нэг хэсэг юм². Чин гүрний Лу Циюн “Ман Тин Фан” шүлэгтээ Пи Па(琵琶), хув хэрэглэж, толгой дээрээ давхар дэнлүүтэй бүжиглэж, дээр нь дэнлүүтээ асааж буй дүр төрхийг багтаасан шөнийн цайллагын хөгжим бүжгийн цогц үзүүлбэрийг дүрсэлсэн байдаг. Энэ нь тухайн үеийн тайзны урлагийн байдлыг харуулаад зогсохгүй нийгэм, шашны үйл ажиллагаанд аягатай бүжиг чухал байр суурьтай байсныг илэрхийлсэн билээ³. Эдгээр сурвалж бичигт тэмдэглэснийг үндэслэн маш олон судлаачид аягатай бүжгийн хэлбэрийг анх ордноос эхэлсэн буюу юань гүрний үеэс эхэлсэн гэдэг үзэлтийг дурдсаныг тодорхойлсон болно. Гэхдээ антропологич Лин Хуй Сян эртний бүжгийн хөгжил цэцэглэлтийн шалтгаан нь: Үйл ажиллагааны таашаал, сэтгэл хөдлөлөө гадагшлуулах таашаал, хэмнэлийн таашаал, дуураймал таашаал дөрвийг багтаадаг гэсэн байна⁴.

Мөн Юань гүрний үеийн Дунхуаны могой агуйн ханын зурагт буй арван зургаан тэнгэрийн дагинасын бүжгийн дундах арван нэгдэх тэнгэрийн дагина нь төвөдөөр Maг-me-ma буюу “Зулт өргөлийн охин тэнгэр” гэж байдаг бөгөөд улаан өнгөтэй, цацрах гэрэл нь тэнгэрийг бүхэлд нь гэрэлтүүлсэн, баруун мутартаа зул дээш нь өргөсөн тэнгэрийн дагина байдаг нь үүний нэгэн жишээ юм. Үүнд шашны тахилгын зан үйлийг дуурайх бүжиг маш олон байдаг, жишээлбэл цамын бүжиг, бүжгийн хөдөлгөөнөөс цацал өргөх зэрэг эл бүхэн нь шашны тахилгын зан үйлийг дуурайсан гэдэг нь илэрхий. “Монголын нууц товчоон”-д тэр хавар дээдсийн тахилгын газар тахилгын идээн шүүс өргөхөд Амбагай хааны хатан Орбай Сохтай хоёр Өөлүн үжинг хожимдож хүргэв гэж тайлгын идээний хувь

¹ 王景志. 中国蒙古族舞蹈艺术论[M]. 呼和浩特: 内蒙古大学出版社, 2009年, 第290页.

² 樊彬. 《燕都杂咏》[M], 长沙石耕山房光绪三十三年版, 转引自罗雄岩. “倒喇”源流新考[J]. 北京舞蹈学院学报, 2005年, 第2期: 第43页.

³ 王克芬. 中国舞蹈通史明清卷[M]. 上海: 上海音乐出版社, 2012年, 第121页.

⁴ 林惠祥. 文化人类学[M]. 北京: 商务印书馆, 2005.

хишгээс хуваан өгсөнгүй билээ⁵ гэж тэмдэглэсэн юм. Монголчуудын заншилд дээдсээ тахих зан үйлийн дунд сүү, сархад зэрэг шингэн идээний дээжийг цөгц, цомоонд хийж өргөхийн дагуу “ хурай хурай хурай ” гэж нар зөв хурайлж, дахин түүнийгээ идээний хувь хишиг болгодог заншилтай байжээ. Үүнээс үзэхэд аягатай бүжиг, хундагатай бүжиг нь эртний шүтлэгийн зан үйлийн хурайлах хөдөлгөөнийг дуурайсан байх магадлалтай бөгөөд сүүлд шашны тахилгын бэлгэдэл болон улирч хувирсан байж болно.

Эртний шашны зан үйлээс үүсэлтэйгээс ордны бүжиг болж хувирсан, одоо болоход найр наадам, үдэшлэг тоглолтын дутагдаж болзошгүй бүжгийн нэг хэлбэр болсон нь яг л аягатай бүжгийн бэлгэдлийн утга агуулгын хувиралтыг илэрхийлж байгаа юм. Аягатай бүжгийг эртний шашны үйл хөдөлгөөнийг бэлгэдсэн бүжгийн хэлбэрээс нүүдэлчдийн амьдралын соёлын бэлгэ тэмдэг болон хувирч хөгжсөнийг судлахдаа монголчуудын түүхэн бүжгийн хэлбэр, нийгэм, шашны үйл ажиллагаанд гүйцэтгэсэн үүргийг судлах шаардлагатай. Монголчууд феодалын нийгмийн үе шатанд орж, ялангуяа Юань гүрэн байгуулагдсаны дараагаар монголчуудын бүжгийн хэлбэрүүд нангиад үндэстний соёлын нөлөөнд автаж, томоохон өөрчлөлтүүд гарч эхэлжээ. Энэ үед бүжиг нь зөвхөн алга таших, хөлөө дэвсэх төдийхнөөр хязгаарлагдахаа больсон бөгөөд нангиад үндэстний ордны бүжгийн элементүүдийг өөртөө шингээж, хэлбэрийг нь улам баялаг болгосон байдаг. Энэхүү соёлын нийлэг нь аягатай бүжиг зэрэг бүжгийн төрлийг анх бий болгоход түлхэц болсон хэдий ч энэ үед аягатай бүжиг нь монголчуудын өвөрмөц бүжгийн онцлогийг бүрэн харуулж амжаагүй байсан билээ. Орчин үеийн тайзан дээрх аягатай бүжиг нь монголчуудын уламжлалт бүжгийн нэгэн төрөл болох бүжгийн хэлбэрээс тайзны тоглолт болж хувирсан байна. Энэ үйл явцаар дамжуулан нүүдэлчдийн шашны зан үйлийн үндсэн элементүүдийг хадгалан үлдээгээд зогсохгүй шинэлэг найрал хөгжмийн арга барилаар нүүдэлчдийн соёлын бэлгэдэл агуулгыг нэмсэн байна. Аягатай бүжгийн орчин үед нь ихэвчлэн уламжлалт бүжгийн элементүүдийг дахин тайлж, уран сайхны аргаар сэргээж, нүүдэлчдийн соёлын онцлог, амьдралын хэв маягийг илүү баялаг, олон талт байдлаар харуулахыг эрмэлздэг.

“Тал нутгийн сархдын дуу” бүжгийн бүтээл бол үүний маш сайн жишээ юм. Энэ нь аягатай бүжгийг гол цөм болгон авч, аяга, савх хоёрыг хослуулан монголчуудын амьдрал, дарсны соёлыг бүжгээр илэрхийлсэн байдаг. Энэхүү бүжгийн эхэнд лимбэний эгшгээр хавсрал ая болгож, сүүтэй цайны анхилам үнэрээр өглөө болсныг илтгэдэг. Энэ нь Монголын уламжлалт соёлыг уриалаад зогсохгүй малчдын хөдөлмөрийг бүжгээр дамжин илэрхийлсэн байна. Бүжгийн оргил хэсэгт аяга, савх зэрэг хэлбэр дүрслэл, бүжгийн хөдөлгөөнөөр дамжуулан монгол бүжгийн олон талт, баялаг байдлыг улам бүр харуулж байжээ. Оргилд нь тэнгэрт цай өргөх үйлдлээр дамжуулан байгаль дэлхийгээ хүндэтгэх, шүтэхийг бэлгэддэг нь монгол соёлын чухал илэрхийлэл болсон байна. Улмаар бүжигчин бүсгүйн эрэгтэй бүжигчинд цай аягалж буй үйлдэл

⁵ Тайчууд Мансан үйлгэрлэн найруулав, “ Монголын нууц товчооны үлгэр”, Өвөр Монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, р42.

нь эрэгтэй, эмэгтэй хүмүүсийн соёлын үүргийг монголчуудын зочломтгой зан араншин, эв нэгдэл, харилцан туслалцах амьдралын гүн ухааныг илэрхийлсэн юм. Төгсгөлд нь бүжигчин эмэгтэйн дүр төрхийг харуулсан бүжгийн зохион байгуулалт нь монголчуудын соёлд эмэгтэйчүүдийн эзлэх байр суурь, үүрэг оролцоог илэрхийлж, монголчуудын нийгмийн эв найрамдал, нэгдмэл байдлыг илэрхийлсэн. Энэхүү зохицуулалтаар “Тал нутгийн сархдын дуу” нь аягатай бүжгийн уламжлалт сэтгэл татам байдлыг харуулахаас гадна нүүдэлчдийн соёлын орчин үеийн бэлгэдэл болгож, монгол соёлын түүхэн залгамж чанар, орчин үеийн тайзнаа дасан зохицох шинэлэг чадварыг харуулсан юм.

Нүүдэл ба суурин соёлын хүмүүсийн хооронд аяганы соёлын тайлбар, бэлгэдлийн утга нь ихээхэн ялгаатай байдаг. Аяга нь хоёр соёл иргэншлийн хэв маягийн үндсэн ялгааг илэрхийлээд зогсохгүй байгаль орчны нөхцөлд хүн төрөлхтний өдөр тутмын хэрэгцээт зүйлд өөр өөр бэлгэдлийн утга агуулга өгч байгааг харуулж байна. Тариалан эрхэлдэг хүмүүсийн дунд аяга нь амьдралын үндсэн хэрэгцээ, тэд нарын байгалийн орчин тойрон нь хэцүү бэрх, тухайн цаг үед тариалангийн хураалт муутай учраас өлсгөлөн амьдралтай учирч байсан болохоор аягыг гэдэс цатгалан аж жаргалтай байхын бэлгэдэл болгодог. Хятадын Ганьсу мужийн соёлд аяга нь өдөр тутмын амьдралын хэрэгсэл төдийгүй хоол хүнс дутахгүй, гэр бүлээрээ бүрэн бүтэн байхын бэлгэдэл болдог⁶. Энд байгаа аягатай бүжиг нь тариалангийн амьдралын үнэ цэнийг магтаж буйг илтгэж, энэ аяга нь аман хишиг, хөдөлмөрийн үр шимийг хүндэтгэх бэлгэдлийн утгыг шингээсэн байдаг. Хурим мэтийн нийгмийн чухал үйл ажиллагаануудад хүмүүс хөдөлмөрийн ашиг шим, үр бүтэмж хэмээн хоол хүнсэнд их анхаарал хандуулж байдгийг харуулж байна. Нүүдэлчдийн хувьд аяганы бэлгэдлийн утга нь байгаль, оюун санааны амьдралтай илүү холбоотой байдаг бөгөөд аяга нь зөвхөн хоол хийх сав төдийгүй байгальтай харилцах хэрэгсэл гэж үздэг. Бүжигчид тэнгэрт тахил өргөхдөө сүүтэй цай буюу идээний дээжээ аяганд хийж тэнгэртээ өргөх нь аягатай бүжгийн хөдөлгөөний нэг хэсэг нь болж, нүүдэл соёлын байгалийг шүтэх заншлын хувьсал нөлөөлөл нь болсон байна. Үүний нэгэн жишээ нь Монгол Улсын Ховд аймгийн торгууд зоны “Ховог” хэмээх торгууд бийн онцлог нь бийч хоёр хөлөө тахимцан зөрүүлж зогсоод, гараа дотогш хумьж, мөрөө огцом хөдөлгөн бийлдэг бөгөөд толгой цээжний хөдөлгөөнийг цээрлэх учир бийлэх болон сургуулилах үедээ толгой дээрээ аягатай сүү, чигээ (айраг) тавьж цалгиан асгахгүйгээр бийлчихвэл чигээнээсээ амсаж, дараагийн хүндээ дамжуулан бийлж бүждэг ёс байна.⁷ Энэхүү соёлын тайлбарт аяга нь нүүдэлчдийн оюун санааны ертөнцтэй нягт холбоотой байж, нүүдэлчдийн зан чанарыг харуулсан соёлын бэлгэдэл болжээ. Эдгээр ялгааны үндсэн шалтгаан нь хоёр соёлын байгаль орчин, үйлдвэрлэлийн арга барилын ялгаатай байдалд оршдог.

⁶ 公兰英. 甘肃民乐顶碗舞的遗存. 音乐茶座[J]. 2012.

⁷ Жав Ж. Бүжгийн урлагийг бүтээх эрдмийн асуудалд. Улаанбаатар, 1990

Дүгнэлт

Аягатай бүжиг нь бэлгэдлийн утга агуулдаг бүжгийн нэгэн төрлийн хувьд нүүдэл соёлд онцгой байр суурь эзэлдэг. Аягатай бүжиг, түүний соёлын бэлгэдлийг судалснаар, нүүдэлчдийн өөрсдийн соёлын үнэт зүйл, итгэл үнэмшил, амьдралын хэв маягийг байгальтайгаа зохицон, энэ урлагийн төрлөөр хэрхэн дамжуулж байдгийг илүү гүнзгий ойлгох боломжтой. Аягатай бүжиг нь эртний шашны зан үйлээс үүдэлтэй бөгөөд тахилын үйл ажиллагаатай нягт холбоотой гэж үзнэ.

Энэхүү бүжгийн хэлбэр нь байгаль дэлхийгээ дээдэлж буйг илэрхийлээд зогсохгүй нүүдэлчдийн амьдралд дасан зохицох, амьдрах чадвараа байнга бэлгэддэг. Цаг хугацаа өнгөрөхөд аягатай бүжиг нь зөвхөн уламжлалт элементүүдээ хадгалаад барахгүй орчин үеийн соёлын олон талт байдлыг өөртөө шингээжээ. Орчин үеийн бүжгийн урлагт аягатай бүжиг, савхан бүжиг гэх мэт бусад бүжигтэй хослуулсан байдаг. Ийм байдлаар бүжиг нь зөвхөн аягатай хөдөлгөөнөөр хязгаарлагдахгүй, илүү өнгөлөг болдог. Нүүдэлчдийн соёлын нэг хэсэг болох аягатай бүжгийн түүх, хувьсал нь нүүдэлчид байгаль дэлхийгээ дээдлэн, аж төрж байдгийг бүрэн харуулж байна. Энэхүү бүжиг нь зугаа цэнгэлийн нэг хэлбэр төдийгүй, нүүдэлчдийн хамтын нийгэмлэгийн талаарх гүн гүнзгий ойлголтыг хөдөлгөөн, хэмнэлийн өөрчлөлт бүрээр дамжуулан илэрхийлдэг соёлын өв, бэлгэдэл юм. Орчин үеийн бүжиг дэглэлт, илэрхийлэл нь аягатай бүжгийн соёлын солилцоо, өв залгамжлалд идэвхтэй үүрэг гүйцэтгэдэг болохыг онцолж, энэхүү уламжлалт урлаг нь соёлын гүн үндэс, бэлгэдлийн утгыг хадгалан орчин үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагад дасан зохицож чадна гэдгийг баталгаажуулдаг.

Ном зүй

- 王景志. (2009). 中国蒙古族舞蹈艺术论[M]. 呼和浩特: 内蒙古大学出版社.
- 樊彬. (2005). 《燕都杂咏》[M], 长沙石耕山房光绪三十三年版, 转引自罗雄岩. “倒喇”源流新考[J]. 北京舞蹈学院学报. 第2期.
- 王克芬. (2012). 中国舞蹈通史 明清卷[M]. 上海: 上海音乐出版社.
- 林惠祥. (2005). 文化人类学[M]. 北京: 商务印书馆
- 公兰英. (2012). 甘肃民乐顶碗舞的遗存. 音乐茶座[J].
- Тайчууд Мансан үлгэрлэн найруулав, “Монголын нууц товчооны үлгэр”, Өвөр Монголын хэвлэлийн бүлэглэл, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо.